



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15
E-mail: info@mrt.gov.mn, <http://www.mrt.gov.mn>

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
Б.АРТУР ТАНАА**

2016.05.25 № 038/07/071/15

Төмөр замын доод бүтцийн тухай

Танай газраас ирүүлсэн дотоод албан бичгийг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2016.05.20-ны өдөр баталсан 038/07/071/22 дугаартай удирдамжийн дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын доод бүтцийн барилга угсралтын ажил /далан, гүүр, хоолой/ байгалийн хүчин зүйл нөлөөнд автсан эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргахаар тус газрын ахлах мэргэжилтэн, Улсын байцаагч Д.Батхүү, Төмөр замын гүүр хиймэл байгууламжийн хяналтын мэргэжилтэн Б.Мөнхбаяр, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ж.Болдхүү, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн замын инженер Э.Ганзориг, гүүр хиймэл байгууламжийн инженер Ч.Баяраа, "Төмөр замын инженерүүдийн нэгдсэн холбоо" ТББ-ийн гишүүн С.Халтарбанди нар газар дээр нь ажиллав.

Нэг. Төмөр замын доод бүтцийн тухай тайлбар

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн захиалгаар Зураг төслийг SeoYeong engineering Co.,Ltd боловсруулж, Ерөнхий гүйцэтгэгч "Самсунг Си энд Ти" ХХК болон түүний туслан гүйцэтгэгч компаниуд барилгын ажлыг хийж байна.

Төмөр замын доод бүтцийн ажлын гүйцэтгэлийг дараах хүснэгтэд үзүүлэв.

1-р хүснэгт. Төмөр замын доод бүтцийн ажлын гүйцэтгэлийн жагсаалт

№	Туслан гүйцэтгэгч компанийн нэрс	Хариуцсан км	Гүйцэтгэл /хувиар/
1	Эсто ХХК	-7+823 - 7+000	83%
2	Нутгийн буян ХХК /1-р хэсэг/	7+000 - 17+000	96%
3	Мапрөүд ХХК /1-р хэсэг/	17+000 - 30+000	93%
4	Жилин мандал ХХК	30+000 - 45+000	75%
5	Мапрөүд ХХК /2-р хэсэг/	45+000 - 58+214	92%
6	Хүслэнт бүтээмж ХХК	62+300 - 70+000	87%
7	Бидний зам /1-р хэсэг/	70+000 - 75+000	90%
8	Билэгт зам	75+000 - 105+000	95%
9	Дардан говь	105+000 - 120+000	80%
10	Бидний зам /2-р хэсэг/	120+000 - 130+000	88%
11	Повэр ложистикс ХХК	130+000 - 140+000	55%
12	Арц суврага ХХК	140+000 - 150+000	66%
13	Монрөүд ХХК	150+000 - 175+000	71%

14	Нутгийн буян ХХК /2-р хэсэг/	175+000 - 185+000	60%
15	Кэй Эйч Эн Ар ХХК	185+000 - 205+000	67%
16	Транскон ХХК	205+000 - 217+550	3%

Хоёр. Хяналт шалгалтаар хийгдсэн ажил

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 208 км төмөр замын доод бүтцийн дагуу явж шалгав.

Төмөр замын доод бүтцэд байгалийн нөлөөнд автсан дараах хэсгүүд илрэв.

- 2.1. “Мапроуд” ХХК-ний гүйцэтгэсэн далангийн 17 км 40 м-ээс 19 км 800 м-ийн хоорондох сэтэрхийн хажуу налуу 12 хэсэг газар усанд ихээхэн хэмжээтэй идэгдсэн /зураг 1/ ул шорооны хажуугийн ус зайлуулах суваг бөглөрснөөс нягтруулсан хучилтын үеэр ус гүйсэн /зураг 2/ байна. Шалтгаан нь үерийн уснаас хамгаалах уулын суваг, нөөц далан хангалтгүй хийгдсэн.
- 2.2. “Жилин Мандал” ХХК-ний гүйцэтгэсэн далангийн 41 км 34 м дэх хэсэгт далангийн хажуу уртын дагуу 60 м газарт үерийн усанд /ойролцоогоор 280 м3/ идэгдсэн /зураг 3/ байна. Шалтгаан нь үерийн усны голдиролыг засаагүй, ус зайлуулах хоолой буруу газар төлөвлөсөн.
- 2.3. “Дардан говь” ХХК-ний гүйцэтгэсэн далангийн 105 км 500 м -ээс 106 км 400 м хоорондох сэтэрхийн хажуу налуу усанд идэгдсэн /зураг 4/ байна. Шалтгаан нь уулын суваг, нөөц далан хангалтгүй хийгдсэн

Гурав. ДҮГНЭЛТ:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд баригдаж байгаа 208 км үргэлжлэх төмөр замын доод бүтцийн 17, 18, 19-р км дэх сэтэрхийн хажуу налуу, хучилтын үе нь байгалийн хүчин зүйл буюу үерийн усны нөлөөнд автаж эвдэрсэн, 41-р км-дэх далангийн хажуу 60 м уртааш газар үерийн усны нөлөөнд автаж эвдэрсэн мөн 105 км-ээс 106-р км дэх далангийн сэтэрхийн хажуу налуу хэсгүүдэд байгалийн хүчин зүйл буюу үерийн усны нөлөөнд автаж эвдэрсэн байна.

Тус төмөр замын доод бүтэц нь замын дээд бүтэц /балласт, дэр, зам төмөр/ гүй байх мөн ачаалалт /галт тэрэгний хөдөлгөөн/-гүй байх нь цаг хугацаа өнгөрөх тусам байгалийн хүчин зүйлс нөлөөлснөөр далангийн ул шорооны нягт хангагдахгүй болох, барилга угсралтын ажил нь дуусаагүй байгаа гүүр хоолойн ил арматуруудын зэврэлт ихсэх, сэтэрхий болон үерийн суваг элсэнд дарагдах эрсдэлтэй байна.

Хавсралт 5 хуудастай.

Хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д.

Төмөр замын дохиолол, холбооны хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Улсын байцаагч



Д.БАТХҮҮ

ХШҮДАГ-ын Гүүр, хиймэл байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтэн

Б.МӨНХБАЯР

Зураг 1. 17-19 км дэх эвдрэл




1. 3/10/11

Зураг 1. Үргэлжлэл



2. 3/4

Зураг 2. Хучилтын үеэр ус гүйсэн байдал



8. 3/49

Зураг 3. 41-р км 34 м дэх далангийн эвдрэл



4. (3/4)

Зураг 4. 105-106 км дэх эвдрэл



Б. 3/4